



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Монгол Улс, 17032, Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө,
Утас: 77135051,
E-mail: www.emd.gov.mn

2025. 05. 20 № 92
танай _____-ны № _____-т
Г _____ Г

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
С.ЭНХБОЛД ТАНАА

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр хуралдаанаар батлагдсан “Олон улсын эмнэлзүйн удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 12 дугаар тогтоолыг хүргүүлж байна.

Хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай.

АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА *И. Сайн* Ц.САРАНТУЯА





ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Олон улсын эмнэлзүйн удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6, 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтаар баталсан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим платформ бүхий "UpToDate" үйлчилгээг нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэн гэрээ байгуулахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (С.Энхболд)-т зөвшөөрсүгэй.

2. Худалдан авах үйл ажиллагаанд шаардагдах 1,503,702,540 (нэг тэрбум таван зуун гурван сая долоон зуун хоёр мянга таван зуун дөчин) төгрөгийг тухайн үеийн америк долларын ханшаар тооцож, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2025 оны үйл ажиллагааны "Мэдээллийн технологийн үйлчилгээ"-ний зардлаас гаргахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (С.Энхболд)-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбоотой дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (С.Энхболд)-т даалгасугай.

3.1. Олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим платформ бүхий "UpToDate" үйлчилгээний худалдан авах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангийн 2026-2027 оны төсвийн төсөлд тусгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор тухай бүр батлуулах;

3.2. Гэрээний дагуу худалдан авсан олон улсын эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийг сар бүр гаргаж, ашиглалт, үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлд хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллах;

3.3. Олон улсын эмнэлзүйн удирдамжийг өөрийн оронд нутагшуулах зохистой хувилбарыг судалж, хэрэгжүүлэх талаар санал боловсруулж танилцуулах;

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын алба (Ц.Сарантуяа)-д даалгасугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2020 оны 20 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

T. M. S.



Т.МӨНХСАЙХАН